



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 11 өдөр

Дугаар М/27

Дадал сум

Түймрийн хохирол тогтоох  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.15 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Агац багийн Сантхааны давааны ар гэх газарт 2025 оны 03 дугаар сарын 08-ны өдөр гарсан түймрийн хохирол тогтоох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

|        |               |                                         |
|--------|---------------|-----------------------------------------|
| Ахлагч | Д.Гэрэлмаа    | (Засаг даргын Тамгын газрын дарга)      |
| Гишүүд | Д.Батзориг    | (Байгаль орчны хяналтын улсын байцаагч) |
|        | Г.Билгүүн     | (Хэсгийн төлөөлөгч)                     |
|        | Г.Ган-Эрдэнэ  | (Агац багийн Засаг дарга)               |
|        | С.Нандинцэцэг | (Нягтлан бодогч)                        |
|        | Б.Урансайхан  | (Газрын даамал)                         |
|        | Ц.Оргил       | (Байгаль хамгаалагч)                    |

2.Түймрийн шалтгаан нөхцөлийг тогтоож, учирсан хохирол, гарсан зардлыг тооцож холбогдох байгууллагад хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Гэрэлмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ш.МӨНХХУЯГ



019000077